



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2018 оны 6 сарын 29 өдөр

Дугаар 262

Улаанбаатар хот

“Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн нэмж гаргах энгийн хувьцааг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 9 дүгээр зүйл, 63 дугаар зүйлийн 63.1.10, Компанийн тухай хуулийн 42 дугаар зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 408 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 5.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн нийтэд санал болгон нэмж гаргах нэг бүр нь 10 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 4,405,600 /дөрвөн сая дөрвөн зуун таван мянга зургаан зуу/ ширхэг хувьцааг бүртгэн тус компанийн нийт гаргасан хувьцааг 15,734,200 /арван таван сая долоон зуун гучин дөрвөн мянга хоёр зуу/ ширхэг байхаар үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахыг Үнэт цаасны газар /Б.Лхагвасүрэн/-т үүрэг болгож, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Ш.Лхагва/-д зөвшөөрсүгэй.

2. Энэ тогтоолын 1-д заасан хувьцаанаас 3,228,600 /гурван сая хоёр зуун хорин найман мянга зургаан зуу/ ширхэг хувьцааг тогтоосон үнийн аргаар тус бүрийн үнийг 850 /найман зуун тавь/ төгрөгөөр “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн тодорхойлсон стратегийн хөрөнгө оруулагчид худалдахыг “Хөвсгөл алтан дуулга” ХК /Д.Дуламсүрэн/-д зөвшөөрсүгэй.

3. Энэ тогтоолын 1-д заасан хувьцаанаас 1,177,000 /нэг сая нэг зуун далан долоон мянга/ ширхэг хувьцааг олон нийтэд захиалгын бүртгэл хийх аргаар анхдагч зах зээлд байршуулж, захиалгын доод үнийг үнэт цаасны танилцуулгад заасны дагуу 850 /найман зуун тавь/ төгрөгөөр тогтоохыг “Хөвсгөл алтан дуулга” ХК /Д.Дуламсүрэн/-д зөвшөөрсүгэй.

4. Нэмж гаргаж буй хувьцааг “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн татан төвлөрүүлэх хөрөнгийн доод хэмжээ болох 3,744,760,000 /гурван тэрбум долоон зуун дөчин дөрвөн сая долоон зуун жаран мянга/ төгрөгийг бүрэн татан төвлөрүүлсэн тохиолдолд нийтэд санал болгон үнэт цаас гаргах ажиллагааг амжилттай болсонд тооцохоор тогтсугай.

5. Хороо анхдагч зах зээлийн арилжааг амжилттай болсон гэж үзсэн тохиолдолд “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт

бүртгүүлж, холбогдох баримт бичгийг ажлын 15 хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэхийг “Хөвсгөл алтан дуулга” ХК /Д.Дуламсүрэн/-д үүрэг болгосугай.

6. Энэхүү тогтоолын 4-т заасан татан төвлөрүүлэх хөрөнгийн доод хэмжээг хангах чиглэлээр дээд зэргийн хүчин чармайлт гарган анхдагч зах зээлд арилжих үйл ажиллагааг зохион байгуулах, арилжигдаагүй үнэт цаасыг өөрийн хөрөнгөөр худалдан авахыг “Бумбат-Алтай ҮЦК” ХХК /Ш.Энхмэнд/-д үүрэг болгосугай.


7. Энэ тогтоолын 6-д заасан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд “Бумбат-Алтай ҮЦК” ХХК /Ш.Энхмэнд/-д хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэхийг мэдэгдсүгэй.

8. Хороо анхдагч зах зээлийн арилжааг амжилттай болсон гэж үзэх хүртэлх хугацаанд үнэт цаасны арилжаанаас татан төвлөрүүлэх хөрөнгийг тусгаарлахыг “Арилжааны төлбөр тооцоо” ХХК /О.Эрдэнэгэрэл/-д үүрэг болгосугай.

9. Үнэт цаасны танилцуулга, холбогдох баримт бичгийг бэлтгэхэд худал, хуурамч, дутуу, төөрөгдүүлсэн, зөрүүтэй, алдаатай мэдээлэл тусгасны улмаас хөрөнгө оруулагчид хохирол учруулсан тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэхийг “Бумбат-Алтай ҮЦК” ХХК /Ш.Энхмэнд/, “БДО Аудит” ХХК /Г.Баянмөнх/, “Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс” ХХН /Ж.Майзориг/, “Одбүртгэл аудит” ХХК /Н.Мягмаржав/-д тус тус анхааруулсугай.

10. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН